

MICC ТЭМДЭГЛЭЛ

MICC.mn

2012 ОНЫ 8 ДУГААР САРЫН 30 (20)

14 хоног тутам гарна

MONGOLIA INTERNATIONAL CAPITAL CORPORATION — Монголын тэргүүлэх хөрөнгө оруулалтын банк

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОВЧ МЭДЭЭ

- Д. Ганхуяг шинээр байгуулагдсан Уул Уурхайн Яамны сайдаар томилогдлоо.
- SouthGobi Цагаан Толгойн нүүрсний орд газрыг Modun Resources-д худалдахаа больсон байна.
- Арав дахь удаагийн Discover Mongolia хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт Улаанбаатарт зохион байгуулагдаж байна.
- Хөгжлийн Банк бонд зарж босгосон 580 сая ам долларыг юунд зарах тухайгаа хэлэлцэж, Таван Толгойн тээвэрлэлтийн төмөр замд 100 саяыг зарцуулахаар болжээ.
- Aspire Mining Овоотын коксжих нүүрсний ордод олборлолт хийх зөвшөөрлийг авлаа. Уг төслийн нөөцийн тодорхойлолт нэмэгдэж болно гэж тэд мэдэгджээ.
- Naranga Resources Сэлэнгийн төмрийн хүдрийн ордыг ашиглах боломжтой гэж мэдэгджээ. Ашиглалтын хугацаа нь 16 жил байхаар төлөвлөгдөж байгаа юм байна.
- Erdene Resources Алтан Нар дахь нөөцийн таамаглалаа ихэсгэжээ. Тус хайгуулын талбайгаас алт болон мөнгөний эрдэсжилт илэрсэн байна.
- Gobi Energy Partners (Manas Petroleum) өрөмдөлтийн гурван газрыг тодорхойлсон бөгөөд энэ ондоо хоёр газарт нь өрөмдөх төлөвлөгөөтэй байна.
- Winsway Coking Coal Монголын төмрийн хүдрийг Хятадад борлуулах гэрээг Хятадын компанитай байгууллаа.
- БНХАУ-ын төрийн зөвлөлийн гишүүн Дай Бингуо Монгол улсад айлчлал хийлээ. Тэрээр Chalco-SouthGobi-гийн хэлцлийн тухай ярилцах төлөвлөгөөтэй байгаа юм байна.


Түүхий эдийн үнийн “супер” мөчлөг





УУЛ УУРХАЙН хувьцаануудын үнэ урт хугацаанд түүхий эдийн үнийг дагадаг. Харин сүүлийн үед ганц Монголд биш, дэлхий даяар томоохон уул уурхайн компаниудын ашиг орлого буурч, хувьцааных нь үнэ унаж байна. 2012 оны эхний хагаст BHP Billiton-ы цэвэр ашиг ойролцоогоор 8 тэрбум ам доллар буюу 58 хувиар унасан бол Anglo American-ых ~\$2 тэрбум (40 хувиар), Rio Tinto-гийнх мөн ~\$2 тэрбум (22 хувиар) унажээ. BHP Billiton Австрали дахь алт, зэс, ураны Olympic Dam төслийн өргөтгөлд зориулсан \$20 тэрбум ам долларын хөрөнгө оруулалтаа тодорхойгүй хугацаагаар хойшлуулжээ.

Компаниудын ашиг буурч байгаагийн гол шалтгаан бол түүхий эдийн үнийн уналт юм. Харин түүхий эдийн үнэ унаж байгаа нь дэлхийн эдийн засгийн түр зуурын удаашралтай холбоотой үзэгдэл үү? Эсвэл түүхий эдийн үнийн “супер” мөчлөгтэй холбоотой илүү урт хугацааны асуудал уу? Үүнд зарим хөрөнгө оруулагчид санаа зовж байгаа нь *Financial*

Рио Тинто компанийн хувьцааны үнэ



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ



өнөөдөр 22,000 зурагтын үнэтэй болоод байна” гэж Австралийн төв банкны ерөнхийлөгч Glenn Stevens саяхан хэлжээ. Гэтэл энэ цагаас хойш төмрийн хүдрийн үнэ ойролцоогоор 30 орчим хувь унаад байна. Ганц төмрийн хүдэр биш, зэс, коксжих нүүрсний үнэ унаж байгаа тухай бид өмнөх дугаарууддаа мэдээллэж байсан. Тиймээс л мөчлөгийн дагуу түүхий эдийн үнэ унах цаг нь болсон уу гэх яриа гараад байна.

Times сонины нийтлэлүүдээс харагдлаа. Тиймээс бид энэ удаагийнхаа дугаарт “супер” мөчлөгийн тухай маргааны хоёр талыг танилцуулъя гэж бодсон юм.

Түүхий эдийн “супер” мөчлөг гэж юу вэ? Өмнөх нүүрнээс харвал, Оюу Толгойн олборлолтыг гартаа аваад байгаа Rio Tinto-гийн хувьцааны үнэ 2000 оноос өмнө Лондонгийн бирж дээр 1,000 (10 фунт стерлинг) давдаггүй байсан бол 2005 оноос хойш огцом өсчээ. Ер нь ганц Рио Тинто биш ихэнх уул уурхайн компаниудын хувьцаа 2000 оны дунд үеээс хойш огцом өссөн нь түүхий эдийн үнэ сүүлийн арван жилд дунджаар дөрөв дахин өссөнтэй холбоотой юм. Энэхүү өсөлтийг “супер” мөчлөгөөр тайлбарлаж болно. Дээрх зургаас харвал түүхий эдийн үнэ сүүлийн 200 жилд 30-40 жилийн зайтайгаар огцом өсч унаж байжээ. Ялангуяа томоохон дайны үеээр түүхий эдийн үнэ огцом өссөн бөгөөд, дайны дараа эргээд унаж байжээ. Өөрөөр хэлбэл түүхий эдийн үнэ урт хугацаанд маш тогтворгүй байдаг байна.


Сүүлийн долоо найман жилийн өсөлтөд ямар нэгэн дайн гэхээсээ илүү Хятадын хөрөнгө оруулалтын өсөлт хамгийн их нөлөөлсөн гэж шинжээчид тайлбарладаг. “Таван жилийн өмнө нэг усан онгоцын тээвэрлэх төмрийн хүдэр 2,200 зурагтын үнэтэй байсан бол

ТЭМДЭГЛЭЛ сонин анхны дугаараасаа л түүхий эдийн үнэ унаж болох тухай анхааруулж байсан. Гэхдээ бид үүнийг түүхий эдийн мөчлөг гэхээсээ илүү дэлхийн эдийн засгийн удаашралтай холбож ярьсан билээ. Дээрх зургийг хараад, түүх дахин давтагддаг гэж үзвэл түүхий эдийн үнэ богино болон дунд хугацаанд нилээд унах төлөвтэй юм байна гэж дүгнэж болно. Түүхий эдийн үнэ сүүлийн жилүүдэд Хятадыг дагаж өссөн юм бол Хятадын эдийн засаг удаашрахын хэрээр эргээд унаж, “супер” мөчлөгийг гүйцээнэ гэж таамаглаж байгаа хөрөнгө оруулагчид цөөнгүй.

Гэхдээ үүний эсрэг хэд хэдэн шалтгаанууд байгаа гэдгийг энд дурдах хэрэгтэй. Нэг бодлын, түүхий эдийн эрэлт ирээдүйд нэмэгдсээр л байна. Харин нийлүүлэлт нь багасна уу л гэхээс биш нэмэгдсээр байна гэж хэлэхэд хэцүү. (Өдөр болгон Оюу Толгой шиг орд олоод байхгүй.) Мөн Хятадын эдийн засаг удааширсан ч Энэтхэг гэх мэт бусад хөгжингүй орнуудын эдийн засаг өснө. Африк одоо болтол маш ядуу байгаа бөгөөд Африк өсөхөд их хэмжээний түүхий эд шаардагдана. Гэхдээ энэ хоёр санаа бол урт хугацаанд илүү хамаатай бөгөөд дэлхийн эдийн засгийн удаашралаас болж түүхий эдийн үнэ цаашид ч унахыг үгүйсгэхгүй. ☺

ЭДИЙН ЗАСАГ ЗУРГААР

ДНБ-ий өсөлтийн задаргаа



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН хорооны мэдээллэснээс харвал 2008 оноос хойш манай орны Дотоодын Нийт Бүтээгдэхүүн дунджаар жил бүр 7 хувиар өссөн байна. Харин салбар бүрийн өсөлтийг нарийвчилж үзвэл зарим салбар (ялангуяа хөдөө аж ахуйн салбар) дунджаар уналттай байжээ. Өндөр өсөлттэй байсан худалдаа, мэргэжлийн үйлчилгээ, тээвэр ба агуулахын үйлчилгээ нь уул уурхайг дагаж өсдөг салбарууд тул сүүлийн гурван жилд эрчимтэй өргөжсөн байна. Харин сонирхолтой нь мэдээлэл холбоо, уул уурхай, үл хөдлөх хөрөнгийн өсөлт нь ДНБ-ийн өсөлттэй тэнцүү, эсвэл түүнээс ч бага байжээ. Өөрөөр хэлбэл худалдаа, мэргэжлийн болон тээврийн үйлчилгээ Монголд дутмаг байсан бөгөөд уул уурхайн салбар ДНБ-ийг түрж өсгөхөд дагаж өссөн байна.


Харин хөдөө аж ахуйн салбар бодит уналттай байсан нь санаа зовмоор мэдээ юм. Дэлхийн хүнсний үнэ нэмэгдэж, АНУ болон ОХУ гандуу байгаа энэ үед хүнсний бодит үнэ улам ч их өсөх эрсдэл байна. Харин манай хөдөө аж ахуйн салбар нь дор хаяж дотоодын эрэлт хэрэгцээг хангах хэрэгтэй.

Хэдийгээр манай эдийн засаг уул уурхай дээр тулгуурладаг гэж Монголчууд ярьдаг боловч Монголын ДНБ-ий ихэнх хувийг үйлчилгээний салбарууд бүрдүүлдэг гэдгийг энд дурдахад илүүдэхгүй биз ээ. Гэхдээ, хэдийгээр уул уурхайн салбар ДНБ-ий ихэнх хувийг бүрдүүлдэггүй ч, бусад салбаруудтай харьцуулахад гадны хөрөнгө оруулалтыг хамгийн их татаж, энэ хөрөнгө оруулалт бусад салбаруудад ч өсөлтийнх нь гол хөтлөгч болоод байна.

Уул уурхайг дагаж, бүр илүү хурдтай өссөн салбарууд нь уул уурхайн үйл ажиллагаанд шаардагдах зүйлсийг хангадаг. Жишээлбэл ДНБ-ий 1%-ийг ч эзэлдэггүй Мэргэжил, Шинжлэх Ухаан, Техникийн үйлчилгээ нь маш хурдан өссөн байна. Манай оронд уул уурхай хөгжиж эхлэснээс хойш олон шинэ компаниуд үүссэн бөгөөд эдгээр нь нягтлан бодогч, Монголын газар зүйг сайн мэддэг геологич, аудитор, химич гэх зэрэг олон мэргэжилтний үйлчилгээг шаарддаг. Өмнө нь эдгээр мэргэжилтнүүдийн үйлчилгээ одоогийнх шиг өндөр эрэлттэй байгаагүй.

Тээвэрлэл, машин засвар, борлуулалт гэх зэрэг салбарууд ч адилхан, уурхайчдын ажилд шаардагдах тул нилээд өссөн. Гэхдээ машины засвар, борлуулалт нь хамгийн өндөр өсөлттэй байгааг мөн машины тоо нэмэгдсэнтэй холбож тайлбарлах нь зүйтэй. Сүүлийн жилүүдэд УБ хотод машины тоо гайхалтай хурдан өссөнийг хэн ч андахгүй. Харин гадаадын хөрөнгө оруулагч, мэргэжилтэд гарцаагүй зочид буудал, ресторанаар үйлчлүүлэх нь тодорхой. Иймээс энэ үйлчилгээний салбар ч өсөлттэй байлаа.

Бодит уналттай байсан салбаруудад санхүүгийн салбар орж байгаа ихэнх хүмүүсийн гайхшралыг төрүүлнэ. Хэдийгээр манай оронд санхүүгийн үйлчилгээний компаниуд ихсэж, санхүүгийн үйлчилгээний чанар сайжирч байгаа ч энэ үзүүлэлт гарсан нь тус салбар цаашдаа өсөх боломжтойг илтгэж байгаа болов уу. Гэхдээ санхүү бол туслагч салбар: бид санхүүг өмсөж, идэхгүй ч санхүүгийн салбар бусад бодит салбаруудын хөгжилд маш чухал үүрэг гүйцэтгэдэг билээ. ☸



MICC

Mongolia's Investment Bank

THIS IS THE MICC JOURNAL, A BI-MONTHLY FINANCE AND ECONOMICS PAPER PUBLISHED BY MICC, THE LEADING INVESTMENT BANK IN MONGOLIA.

МIСС хөрөнгө оруулалтын банкны тухай
МIСС нь компанийн санхүүжилт, үнэт цаасны арилжаа, судалгаа, хөрөнгийн удирдлага зэрэг цогц үйлчилгээг дотоод гадаадын харилцагчиддаа санал болгодог Монголын ууган хөрөнгө оруулалтын банк юм.

МIСС ТЭМДЭГЛЭЛ – ийн тухай
Хоёр долоо хоног болгон гарах энэ бяцхан сонин танд эдийн засаг, санхүүгийн мэдээлэл өгөх боловч хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөхгүй.

Таны эрсдэл таны хариуцлага.

2012/8/30

Мэдээллийн эх сурвалж: Bloomberg, Монголын Хөрөнгийн Бирж, Financial Times, Financial Sense, Stifel Nicolaus & Co., U.S. Census, EIA, USDA, Монголын Статистикийн Газар.